



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 8/18

Улаанбаатар хот

**Э.Ундармаад нэг удаагийн буцалтгүй  
тусламж үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.5 дахь заалт, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8, Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нярав Энхтайваны Ундармаагийн гэр бүлийн хүн нас барж, ар гэрийн гачигдал гарсан тул нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2.Тусламж үзүүлэхэд шаардагдах 300,000 (Гурван зуун мянга) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.БАТЖАРГАЛ



**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 8/43

Улаанбаатар хот

**Шагнаж урамшуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8.2.7, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Даргын дэргэдэх зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар албан хаагчдын 2023 оны жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин, идэвх оролцоог үнэлж дүгнэсний дагуу ажил хөдөлмөрөөрөө хамт олноо манлайлан ажилласан Маркетинг, олон нийттэй харилцах харилцаа хариуцсан мэргэжилтэн Э.Энгүүнийг нэг сарын цалингаар шагнаж урамшуулсугай.

2.Урамшууллыг цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас бодож олгохыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.БАТЖАРГАЛ